



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: ХААИС, Мал аж ахуй, биотехнологийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Хүнсний чанар, аюулгүй байдал

Индекс: Бакалаврын хөтөлбөр 072103

Шинжээчийн баг:

Ахлагч: Я. Баярхүү /Идэр их сургуулийн хүнсний технологийн тэнхимийн зөвлөх багш, доктор, дэд профессор/

Гишүүд: Г. Оюун /Хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн САМО институтын гүйцэтгэх захирал, доктор/

А.Амаржаргал /ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн/

Он сар өдөр: 2022.04.26

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Шалгуур 6: Багшлах бүрэлдэхүүн

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

- АНУ Америкийн Нэгдсэн Улс
- БНСУ Бүгд Найрамдах Солонгос улс
- БНТУ Бүгд Найрамдах Турк улс
- БНХАУ Бүгд Найрамдах Хятад Ард улс
- БСХҮТ Бүтээгдэхүүн судлал, хяналт үнэлгээний тэнхим
- БСШУС Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны сайд
- БШУЯ Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
- БСШУЯ Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
- БҮТ Биотехнологи үржүүлгийн тэнхим
- БТХТ Бэлчээр тэжээллэг химийн тэнхим
- БМИҮЗ Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
- ЕБС Ерөнхий боловсролын сургууль
- ЖДҮ Жижиг дунд үйлдвэр
- Кр Кредит
- МААБС Мал аж ахуй биотехнологийн сургууль
- МААТ Мал аж ахуйн технологийн тэнхим
- МННБҮХ Монголын ноос ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо
- МТЗ Монголын төмөр зам
- МУ Монгол улс
- МУБИС Монгол Улсын Боловсролын их сургууль
- МУИС Монгол Улсын их сургууль
- МХХ Мэргэжлийн хөтөлбөрийн хороо
- МЭС Мал эмнэлгийн сургууль
- НДШ Нийгмийн даатгалын шимтгэл
- НӨХГ Нийслэлийн өмчийн харилцааны газар
- ОУ Олон улс
- ОХУ Оросын холбооны улс
- ОУБ Олон улсын байгууллага
- ОУХТ Олон улсын худалдааны төв
- ОХ Оюутны холбоо
- ОХЭДТ Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв
- ОЭШБХ Оюутны эрдэм шинжилгээний бага хурал
- ӨМӨЗО Өвөр Монголын өөртөө засах орон
- СБЗА Сургалтын бодлого, зохицуулалтын алба
- СЭЗДС Санхүү эдийн засгийн дээд сургууль
- УИХ Улсын их хурал
- ХАА Хөдөө аж ахуй
- ХААБЧЭАҮ Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ
- ХААИС Хөдөө Аж Ахуйн их сургууль
- ХААШУЗ Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны зөвлөл
- ХНХЯ Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
- ХСИС Хууль Сахиулах их сургууль
- ХХАА Хүнс, хөдөө аж ахуй
- ХХААХҮЯ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- ХЧАБ Хүнсний чанар, аюулгүй байдал

- ЧУЗА Чанарын удирдлага, зохицуулалтын алба
- ШУ Шинжлэх ухаан
- ШУТС Шинжлэх ухаан технологийн сан
- ШУТИС Шинжлэх Ухаан, Технологийн их сургууль
- ЭЕШ Элсэлтийн ерөнхий шалгалт
- ЭЗБС Эдийн засаг, бизнесийн сургууль
- ЭМД Эрүүл мэндийн даатгал
- ЭШБХ Эрдэм шинжилгээний бага хурал
- ЭШХ Эрдэм шинжилгээний хурал

ГАДААД ҮГ

- SAC Хүнсний эрх зүйн хороо
- CDIO Сэтгэх, зохиох, бүтээх, хэрэглэх
- FAO Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
- GAP Хөдөө аж ахуйн зохистой дадал
- GHP Эрүүл ахуйн зохистой дадал
- GMP Үйлдвэрлэлийн зохистой дадал
- ISLS Шинжлэх ухааны мэдээллийн систем
- ISO Олон улсын стандартчилалын байгууллага
- KOICA БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага
- LMS Удирдлагын мэдээллийн систем
- MULS Хөдөө аж ахуйн их сургууль
- PLOs Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн
- ULMS Их сургуулийн сургалтын удирдлагын тогтолцоо

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Хөдөө аж ахуйн их сургууль, Mongolian University of Life Sciences, Мал аж ахуй, биотехнологийн сургууль School of Animal Science and Biotechnology	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Хүнсний чанар, аюулгүй байдал, Food quality and safety	
Индекс	Бакалаврын хөтөлбөр 072103	
Шинжээчид	<ol style="list-style-type: none"> 1. Я. Баярхүү (Идэр их сургуулийн хүнсний технологийн тэнхимийн зөвлөх багш, доктор, дэд профессор) 2. Г. Оюун (Хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн САМО институтын гүйцэтгэх захирал, доктор) 3. А. Амаржаргал (ХХААХҮЯ-ны Хүнсний бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн) 	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Ж.Мөнхбилэг - БМИҮЗ-ийн магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.03.29	Шинжээчийн багийг томилох
	2022.03.31	Шинжээчидтэй гэрээ байгуулах
	2022.03.29-31	Шинжээчдэд өөрийн үнэлгээний тайланг хавсралтын хамт хүлээлгэн өгнө.
	2022.04.11	Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.04.13-14	Сургууль дээр очиж шинжээчид ажиллана.
	2022.04.22	Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.04.26	Шинжээчдийн үнэлгээний тайланг сургуульд илгээж санал авна.
	2022.04.27	Сургууль үнэлгээний тайлантай танилцаж, тайлбар, нотлох баримтыг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.04.28	Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эд баялгийг ашиглах, бэлтгэн нийлүүлэх, боловсруулах үе шатанд чанар, эрүүл ахуйн үнэлгээ өгөх, аюулгүй байдалд хяналт тавих, зах зээлийн эргэлтэнд оруулах, онол арга зүйн мэдлэг, ур чадвар эзэмшсэн, харилцааны өндөр соёлтой, хариуцлага хүлээх чадвартай, бүтээлч сэтгэлгээтэй мэргэжилтэн бэлтгэгдэнэ.

Хөтөлбөрийн нэр: Хүнсний чанар, аюулгүй байдал

Хөтөлбөрийн мэргэших чиглэл: ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ

Хөтөлбөрийн индекс: Бакалаврын хөтөлбөр 072103

ХӨТӨЛБӨРИЙН ТОДОРХОЙЛОЛТ:

“Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөр нь ХАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн бүх үе шатанд чанар, эрүүл ахуйн үнэлгээ өгөх, хяналт тавих мэдлэг, ур чадвар, дадал бүхий мэргэжилтнийг бэлтгэн гаргана.

СУРГАЛТ ЯВУУЛЖ ИРСЭН ТҮҮХ, ТУРШЛАГА

Анх ХААИС-ийн бүтцэд ЭТХС-ийг 1999 онд үүсгэн байгуулахад “ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ” мэргэжлийн ангийг нээж, 63 оюутантайгаар хичээл сургалтыг эхлүүлж “Бүтээгдэхүүний хяналт, үнэлгээ”-ний тэнхимд харъяалуулсан. Тус тэнхим “ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ” мэргэжлээр ХАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний шинж чанар, олон улсын болон өөрийн орны стандарт техникийн нөхцөл, ариун цэвэр, эрүүл ахуйн хяналтын үйл ажиллагаатай холбоотой хууль, журам, зааврууд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, боловсруулах, хадгалах технологийн горим, чанар, эрүүл ахуйн шинжилгээний аргуудыг судалж, лабораторийн шинжилгээг орчин үеийн аргаар хийж, үнэлгээ өгөх чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чиглүүлэн ажилладаг.

2021-2022 оны хичээлийн жилд 23 дахь жилдээ элсэлт авч 159 оюутантайгаар сургалт, эрдэм шинжилгээ, хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байна.

Тус хөтөлбөр нь 2013 оны 5-р сард мэргэжлийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орж, 2013 оны 10 дүгээр сарын 09-ний өдөр “ХАА-н бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ” мэргэжлийн хөтөлбөрийн магадлан итгэмжилсэн гэрчилгээг хүлээн авсан. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллагад эрдмийн зэрэг хамгаалсан, боловсролын байгууллагад 9-22 жил ажилласан магистр (22%), доктор (64%), дэд профессор (14%) багш нар ажиллаж байна.

Тус хөтөлбөрөөр 2003-2021 онд нийт 900 гаруй оюутан төгсөн гарч мэргэжлийн хяналтын газар, хилийн мэргэжлийн хяналтын албанд байцаагч, улс, аймаг, орон нутгийн төр захиргааны байгууллагад хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн, хүнсний бүтээгдэхүүний магадлан шинжилгээний лабораторид шинжээч, хөнгөн ба хүнсний үйлдвэр, хүнсний зах, худалдааны төвүүдэд эрүүл ахуйч, эрдэм шинжилгээний болон сургалтын байгууллагад судлаач, эрдэм шинжилгээний ажилтан, багш зэргээр амжилттай ажиллаж байна.

Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- ХНХЯ-ны хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, 2019 он
- Төрийн болон салбарын бодлого, үндэсний хөтөлбөрүүдийн зорилт, чиг хандлагатай уялдуудан хийсэн “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн STEEP шинжилгээ
- Хөтөлбөрийг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хэрэгжүүлэх, ажил олгогчийн шаардлагад нийцсэн төгсөгчийн загвар гаргах зорилгоор хийсэн хөтөлбөр төлөвлөлтийн PDCA шинжилгээ
- “Хөтөлбөрийн шинэчлэл-хамтын ажиллагаа” хэлэлцүүлгийн зөвлөмж, 2015 он
- Сургуулийн хэмжээнд гаргадаг оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны дүн (2015-2021он)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хүнсний чанар, аюулгүй байдлын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг дотоодын 1, гадаадын 4 их сургуулийн хөтөлбөртэй харьцуулж, нийцлийг тодорхойлсон.
- Токиогийн ХААИС-ийн “Шим судлал, хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрийн хичээлүүдтэй харьцуулан задлан шинжилгээ хийхэд хүнсний аюулгүй байдлын чиглэлийн хичээлүүдийн 90% нь нийцсэн дүн гарсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн ялгарах чанар (сургуулийн онцлог, багшийн чадавхи, сургалтын бааз)-ыг судалгаанд үндэслэн тодорхойлох

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн онцлогийг нийгэмд (элсэгч, ажил олгогч, хамтран ажилладаг байгууллага) таниулах ажлыг илүү оновчтой зохион байгуулах
- “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг дотоодын их сургуулийн хөтөлбөртэй задлан шинжлэх байдлаар харьцуулж, хөгжүүлэх

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг ХААИС, МААБС-ийн эрхэм зорилго, алсын хараанд нийцүүлэн, харилцан уялдаа холбоотой тодорхойлсон байдал
- Хөтөлбөрийн зорилго, зорилтын GAP шинжилгээ хийж, нөхцөл байдлыг үнэлэн, хүрэх үр дүнг тодорхойлсон байдал
- Хөтөлбөрөөр төгсөгчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадалыг зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан гаргасан GAP шинжилгээ
- Төгсөгчдийн эзэмших (PLO) мэдлэг, ур чадвар, хандлагын тодорхойлолт

- Оролцогч ба сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд суурилан хөтөлбөрийг 2015, 2017 онуудад шинэчилсэн баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Периодын буюу богино улирлын системийг нэвтрүүлж, сургалтыг явуулдаг.
- Ажил олгогч байгууллагуудын төлөөллөөс авсан судалгааны үндсэн дээр төгсөгчдийн давуу, сул талыг тодорхойлж, “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрөөр төгсөгчийн загварыг шинэ зууны иргэний боловсролын 4 тулгуурт зарчим болон ажил олгогчийн санал, зөвлөмжид тулгуурлан шинэчлэн боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах, тэднийг сонсох, шинэ төгсөгчдөд туслах, хамтран ажиллах

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг багш, оюутан болон оролцогч талуудад мэдээлэн таниулах ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БШУ-ы сайдын холбогдох тушаалууд
- ХААИС-ийн захирлын холбогдох тушаалууд
- Сургалтын бодлого зохицуулалтын албанаас зохион байгуулсан суралцагчид, багш нар, төгсөгчид, ажил олгогчид, салбарын яам мэргэжлийн байгууллагаас авсан сэтгэл ханамжийн судалгаа, дүгнэлтүүд
- Сургалтын төлөвлөгөөний хичээлүүд ба хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт хоорондын хамаарлыг харуулсан сургалтын төлөвлөгөөний матриц
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварууд хөтөлбөрийн зорилтууд хоорондын уялдаа холбоо
- Сургалтын төлөвлөгөөн дөх хичээлүүдийн стандарт, тухайн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт (CLO) сэдэв хоорондын хамаарал
- Хичээлүүдийн залгамж холбоог хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэж тогтоосон байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХАА-н гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хяналт, үнэлгээг анхан шатны боловсруулалтаас хэрэглэгч хүртэлх үе шатуудад тавих мэдлэг, чадварыг энэ хөтөлбөрөөр олгодог.
- Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд сургалт- үйлдвэрлэлийн дадлага, төгсөлтийн ажлын эзлэх хувийг 2 дахин нэмэгдүүлж нийт 9 кр, ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийн харьцааг 30:25:45 болгож, нийт 124 кр судлахаар боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Мэргэшүүлэх зарим хичээлийн стандартын (ХАА-н бүтээгдэхүүний чанарын удирдлага, ХАА-н бүтээгдэхүүний олон улсын хяналт) агуулгыг дахин хянах, давхцал байгаа эсэхийг нягтлах

Зөвлөмж:

- “Байцаагчийн эрх зүй”, “Чанарын хяналт, стандартчилал, эрх зүй” ХАА-н бүтээгдэхүүний олон улсын хяналт гэх мэт хичээлүүдийн агуулгыг нэгтгэх, интеграцчлах талаар судлах, хичээлээр олгох мэдлэг, ур чадварыг сэдэвтэй нь уялдуулж тодорхойлох

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хичээлийн стандарт хөтөлбөр тэдгээрийн агуулга, нийцэмж, шинэчлэлт
- Хичээлийн индекс, үр дүнгийн матриц, түүний хөгжүүлэлт
- Удирдлагын мэдээллийн систем, программ хангамж, түүний ашиглалт, сонголт, хөгжүүлэлт
- Үйлдвэрлэлийн дадлага, тушаал, гэрээ, удирдамж, тайлан, сайжруулалт
- Хичээл хоорондын залгамж холбоо /хөтөлбөрийн мод/, мөрдөлт

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, хичээлүүд нь эргэх холбоо бүхий харилцан уялдаатай, сонгох боломжтой, шинэчлэл хөгжүүлэлт хийж ирсэн байна. Тухайлбал: 2010 оноос ХААН КАМПУС хөтөлбөр, 2008 оноос цахим их сургуулийн технологийн бүрдүүлэлт хийж E-сургалтын хэлбэрт шилжүүлж алсын зайн сургалтыг амжилттай хэрэгжүүлсэн байна.
- 2006-2014 онд оюутны UNIFACE программ, 2014 оноос ULMS.1.0 программыг өмнөх программтай хослуулан ашиглаж, 2015, 2020 онуудад сургалтын удирдлага мэдээллийн системийг боловсронгуй болгож хичээл бүрийн батлагдсан стандарт хөтөлбөрийг удирдлагын мэдээллийн системд оруулсан нь оюутан сургалтын төлөвлөгөөг харах, хичээл болон багшаа сонгох, суралцах хувиараа төлөвлөх, багшид үнэлгээ өгөх, төлбөрийнхөө хэмжээг харах, улмаар цахимаар төлөх, шилжилт хөдөлгөөнийг цахимаар гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн байна.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн нийцэмжид боловсролын суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлүүдийн зохистой харьцааг баримтлан үр дүнг суралцагчийн эзэмших суурь мэдлэг төдийгүй ур чадварыг үнэлэхэд чиглүүлэн нийт 10 үзүүлэлт мөрдөж буй нь цогц чадамж олгоход чиглэсэн байна.
- Тодорхой чиглэлүүдээр сэтгэл ханамжийн судалгаа явуулж, нэгтгэн дүгнэж, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн байна. Төгсөгчдөөс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүнд үндэслэн сургалт-үйлдвэрлэлийн дадлагыг нэмэгдүүлж 42 хоног болгосон нь төгсөгчдийн практик ур чадварыг сайжруулж, сургалт үйлдвэрлэлийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.

- Оюутны суралцах багц цагийн хэмжээг I-III курсэд 33-36 кредит, IV курсэд 19 кредит байхаар төлөвлөсөн нь төгсөлтийн /бичих төлөвлөх, судлах, үр дүнд боловсруулалт хийх, нэгтгэх зэрэг/ ажлаа бие дааж гүйцэтгэх ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн байна.
- Суралцагсдад хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний талаархи цогц мэдлэг олгож ирсэн туршлагатай.

Анхаарах асуудал:

- Хүнсний бүтээгдэхүүний боловсруулалтын технологийн үндсийг мэдэхгүйгээр түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, түүн дотроо үйлдвэрлэлийн явц дахь чанар, эрүүл ахуйн хяналтыг бодитой үнэлэх боломжгүйг тооцож, мэргэжлийн суурь “Хүнс судлал” “Хүнсний үйлдвэрлэлийн тогтвортой хөгжил зэрэг хичээлийг заавал судлахаар оруулах боломжийг судлах
- “Ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэлгээ” хичээлийн стандарт хөтөлбөрт үр тариа, гурил будаа, талх талхан бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ сэдвээр лекц 2 цаг, эсвэл лабораторийн ажил 2 цаг байгаа нь технологийн суурь мэдлэг олгоход бага байгааг анхаарах
- Сургалтын дадлагын “Технологи, эрүүл ахуй” хичээлийн стандарт хөтөлбөрт 10 үйлдвэр ААН-д очиж танилцах, үнэлгээ өгөхөөр тусгасан ч энэ нь дадлагын удирдамжаас зөрүүтэй байгааг засах
- Хүнсний мэргэжлийн хичээлээр багшаа сонгох боломжийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Ижил индекс бүхий мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж буй үндэсний бусад сургуулийн сургалтын хөтөлбөрийг судлах, сайн туршлагын дагуу өөрчлөлт, сайжруулалт хийх
- Хичээлүүдийн лабораторийн ажлын сэдвийн давхцалыг арилгаж, лабораторийн ажлаар суралцагчийн эзэмших чадвар, дадлыг системтэй, тодорхой болгох

Шаардлага:

- 072103 индекстэй “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн агуулгад хүнсний үйлдвэрлэлийн технологийн суурь мэдлэг олгох цагийг нэмэгдүүлэх

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь суралцагч төвтэй, хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын арга зүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын арга зүйд хийсэн анализ судалгааны баримт, материал
- Хичээлийн стандарт, хөтөлбөрүүд
- Лабораторийн ажлын сэдэв, гарын авлага, материал
- Оюутны дадлагын ажлын тайлан
- Сэтгэл ханамжийн судалгааны дүн

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн агуулга нь суралцагчийн чадамж, идэвхид суурилсан оюутан төвтэй, сургалтын арга нь суралцагч төвтэй.
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, төгсөгчийн эзэмших ур чадвартай уялдуулан туршилтын болон идэвхитэй сургалтын арга хэрэглэдэг. Онолын мэдлэгийг кэйсд суурилсан, асуудалд суурилсан, зориулагдсан орчинд суурилсан, туршилтад суурилсан, зохиол

түүхэн явдалд суурилсан сургалтын аргуудаас сонгон хичээлийн стандарт хөтөлбөрт тусгасан.

- Сургалтын арга зүйг шинэчлэн сайжруулахад модуль төлөвлөлт, интерактив, инновац, үр дүнд суурилсан, идэвхитэй, хосолсон сургалтын аргуудыг нэвтрүүлж, сургалтын үр дүнгийн жагсаалт ба сургалтын хөтөлбөрийг 2 бүрэлдэхүүн хэсгээр /зохион бүтээх төсөл гүйцэтгэх болон туршилт явуулах/ зохион байгуулах аргыг ашиглаж байгаа нь хөтөлбөрийн зорилготой уялдсан төдийгүй ажил олгогчдын сонирхолд нийцсэн, үйл ажиллагаа, суралцагчийн харилцаа, олгох чадвар, үр дүнд чиглэж байгаа нь өмнө мөрдөж байсан аргуудаас дэвшилттэй.
- Багш нарын сургалтын арга зүй, мэдлэг ур чадвар, шаардлага хангалтыг оюутны сэтгэл ханамжийн судалгаагаар тодорхойлж сургалтад хамруулах, урамшуулах, харилцан суралцах арга хэмжээг бүрэлдэхүүн сургуулиудын хүрээнд хэрэгжүүлж, хөгжүүлэлт хийдэг, багш нарыг 2018-2021 онд багшийн хөгжлийн төвд сургалтанд хамруулсан, заах арга зүйн 2019 оны үнэлгээ 4.2 оноо буюу “сайн”.
- Ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний үнэлгээ хичээлийн стандарт хөтөлбөрөөр хагас боловсруулсан ноос ноолууран бүтээгдэхүүн, ээрмэл утас болон анхан шатны боловсруулалттай болон боловсруулсан арьс шир, тэдгээрийн зориулалт, төрөл ангилал, чанар байдлын үнэлгээ хийх чадвар олгоход орчин үеийн багажуудаар тоногдсон орчинд лабораторийн ажлуудыг гүйцэтгэдэг. Лабораторийн хичээлийн аргачлалыг сэдэв тус бүрээр үлгэр жишээ боловсруулан мөрдөж буй нь төгсөгчдийн хөрвөх чадварт эерэг нөлөөтэй байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн лабораторийн (хүнсний технологи, хими гм) хичээлийн багаж тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж шинэчлэн тоноглох, лабораторийн хичээлийн хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Мэргэжлийн хичээлийн сэдвийн хүрээнд орох лабораторийн ажил тус бүрээр суралцагчид зориулсан тараах материал, гарын авлага, аргачлал боловсруулж мөрдөх

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний арга зүйн судалгаа,
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, байнга сайжруулдаг. 2016 онд “ХААИС-ийн бакалаврын сургалтын журам”-ыг шинэчлэн баталж мөрдсөн. Үндсэн улирал тус бүр 8 долоо хоног, нэмэлт улирлын хугацаа 4 долоо хоног, үндсэн улирал хоорондын нэг 7 хоногт багш дүнгээ эцэслэн гаргаж, сургалтын нэгдсэн системд оруулдаг.
- 2015 оноос суралцагч төвтэй сургалтад шилжиж, онолын мэдлэгийг практик ур чадвартай хослуулах, асуудалд суурилсан сургалтаар багаар ажиллах, харилцааны ур чадвар эзэмшүүлэх, зөв хандлагыг төлөвшүүлэх сургалтын технологи арга зүй

нэвтрүүлж, онолын мэдлэгийг 40, мэргэжлийн ур чадвар, бие даалтыг 40, хандлага ур чадварыг 20 оноогоор үнэлж хяналтын ажил, сорил, бодлого, зураг тооцоо, дасгал, реферат, илтгэл, лаборатори, дадлагын хамгаалалт, тайлан, орчуулга хийх зэргийг асуулт хариулт, чөлөөт ярилцлага, маргаан мэтгэлцээн, ажиглалт, бүтээл, бичгийн хэлбэрийн зохистойг сонгон хэрэгжүүлдэг болсон.

- Суралцагсдыг тасралтгүй хөгжүүлэхэд илтгэл, өгүүлэл, эссэ, төсөл зэрэг субъектив үнэлгээний Рубрик аргыг ашиглах, “Хичээлээр эзэмших хувь хүний ур чадвар, хандлагыг үнэлэх зөвлөмж”-ийг бүх хичээлийн стандартын дагуу боловсруулж оюутныг үнэлэх, хөтөлбөрийн хороогоор хэлэлцүүлэн баталгаажуулж мөрдсөн.
- 2016-2021 оны I-IV курсын оюутнууд болон 2019-2021 онд төгсөгчдийн сурлагын голч дүн 2019 оноос жил бүр өссөн нь суралцагсдын мэргэжлийн мэдлэг чадвар өсөхөд хувь хүний хандлага, ур чадвар эерэг нөлөөлсөн гэж үзэх үндэс байна.
- Оюутан хичээлийн дүнг цахимаар харахын өмнө сургалтын үйл ажиллагаа, чанар, орчин, хүртээмж болон удирдлага, ажилтны үйлчилгээний чанарт үнэлгээ өгөх 38 асуулт бүхий сэтгэл ханамжийн судалгаанд заавал хамрагдахаар зохицуулалт хийсэн нь дэвшилттэй.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- “Өөрийн үнэлгээний тайлан” болон газар дээр нь хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, туршилтын бааз, номын сан, оюутны байр, үйлчилгээний бусад нэгжүүд
- Мэргэжлийн хөтөлбөрийн харъяалалд багш нарын 6 өрөө, эрдмийн зөвлөлийн 1, уулзалтын 1, оюутны зөвлөлийн 1 өрөөтэй, цахим сургалтын 1, лекцийн 3 танхим, 7 лаборатори, сүүний бичил цех, чацарганы эх цэцэрлэгтэй
- 2014 онд КОЙКА–ийн хөрөнгө оруулалтаар Сүү судлалын, 2018 онд Загас үржүүлгийн лабораториудыг байгуулж, 2013 онд ХАА-н бүтээгдэхүүний нян судлалын лаборатори, 2016 онд мах судлалын лаборатори, 2014 онд Ноос судлал, 2016 онд Арьс шир судлалын лаборатори байгуулсан.
- Номын сан нь амралтын өдөр ажилладаг, гэрээр 1-3 хоногийн хугацаатай ном олгодог, оюутны байр нь уншлагын өрөөтэй, интернеттэй, цахилгаан зуух, хөлдөөгч бүхий хоолны өрөө, 20 хүнд 1 суултуур, шүршүүр бүхий ариун цэврийн өрөө, давхар бүрт угаалгын өрөөтэй.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Чацарганын эх цэцэрлэгийг түшиглэн сургалт, үйлдвэрлэлийн дадлага, судалгаа хөгжүүлэлтийн ажил эхлүүлсэн.
- Сүүний технологийн туршилтын цехэд шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлт хийдэг.

Анхаарах асуудал:

Суралцагч төвтэй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвхөн хичээл сургалтын ажил төдийгүй үйлчилгээний чанар, хүртээмжид анхаарч сайжруулах шаардлагатай дор дурьдсан асуудал байна.

- Оюутны нийтийн үйлчилгээний ариун цэврийн өрөөний хүртээмж, үйл ажиллагааг сайжруулах, суултуурыг шинээр солих, тоог нэмэгдүүлэх, угаалтуурын бүрэн бүтэн байдлыг хангах.
- Хичээлийн байрны оюутны хоолны газрын үйл ажиллагаа, ариун цэвэр, эмх цэгцийг сайжруулах, зөв боловсон үйлчилгээг хэвшүүлэх.
- Оюутан сурагчид хичээлийн завсарлага, цонхтой цаг зэрэг чөлөөт цагийг үр дүнтэй /хичээлээ давтах, анги хамт олноороо цуглан харилцан ярилцах, санал бодлоо солилцох/ өнгөрүүлэхэд зориулсан, зохих тохижилт тоноглол бүхий өрөө, булан, цэг, орчин хангалтгүй байгааг анхаарах.

Зөвлөмж:

- Дээр дурьдсан үйлчилгээнд сургуулийн зүгээс хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ эрүүл ахуйн үнэлгээч мэргэжлээр суралцаж буй оюутнуудын хүчийг дайчлах, судалгаа, шинжилгээний объект болгон ашиглах боломж байна.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын хичээлийн техник хангамжид зориулан 5.650.0 мян.₮-өөр 5 төхөөрөмж худалдаж авсан.
- 2019-2020 онд цахим хичээлийн иж бүрдэл, программ хангамж, ашиглалтыг сайжруулсан.
- Номын санд 2016-2020 онд жилд 37.0-78.0 сая төгрөг, нийт 285.4 сая төгрөгөөр номын бүрдүүлэлт баяжуулалт хийж, тогтмол хэвлэл захиалгад 36.2 сая төгрөг зарцуулсан.
- Цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулж дижитал номын сангийн шинэ техник, технологийг нэвтрүүлж Монгол, Англи, Герман, Япон хэл дээр ном сурах бичгийн каталог, тогтмол хэвлэл, нийтлэл, эрдэм судлалын ажил, CD-book, судалгааны ажлын CD каталог буй болгон төрөл бүрийн хэлбэрээр ашиглах боломжийг тус тус бүрдүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017 оноос өөрийн сургуулийн мэдээлэл технологийн мэргэжилтнүүдийн зохиосон шинэ программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ЭШ-ний ном, судалгааны ажил, сэтгүүлийг хэрэглэгчдэд хүргэх ажлыг зохион байгуулж буй нь сайшаалтай.

3.3. Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрийн хангамж хүртээмж, үйлчилгээний чанарыг өөрийн үнэлгээний тайлан, ашиглаж буй бүртгэл судалгаа, жагсаалт
- Номын сангийн ажилтан, үйлчилгээний чанар, номын хангамж хүрэлцээ жил бүр сайжирч 2020 онд 22 мэргэшсэн ажилтантай, 200 гаруй мянган боть ном, CD, судалгааны ажил, 2 салбар номын сан, 9 тасаг нэгжтэй болж өргөжиж, гэрээр ном олгох фонд, уншлагын 2 танхим, интернет танхим, номтой ажиллах тасаг, лавлагаа

ном зүйн тасаг, архив гэсэн бүтэцтэй. Энд 230 гаруй хүний суудалтай 3 уншлагын танхим, 20 гаруй компьютертэй цахим уншлагын танхим багтана.

- Номын санд мэргэжлийн үндсэн 8 чиглэлээр, 3 хэлээр хэвлэсэн, 8400 гаруй ном, сурах бичиг ашиглагдаж байгаа бөгөөд эдгээрийн хүрэлцээ хангамжид хийсэн судалгаагаар 42% нь маш сайн, 39% нь сайн, 13 % нь дунд, 6% нь муу гэж үнэлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС нь 2015 онд МНСК-ийн гишүүнээр элссэн нь мэргэжлийн мэдээллийг олон улсын 6 эх үүсвэрээс шууд авч ашиглах боломж бүрдүүлсэн.
- 2016 оноос БСШУСЯ-ны дэмжлэгтэйгээр Дэлхийд нэр хүндтэй “Springer Nature” цахим системийг төрийн өмчийн 6 их сургуулийн хүрээнд ашиглаж эхэлсэн бөгөөд улмаар 2017, 2018 онд цахим системээр сургууль хооронд мэдээллийн сангаас хамгийн олон өгүүлэл, таталт, хандалт хийсэн байгууллагын шалгаруулалтад оролцох болсон.

Зөвлөмж:

- Сэтгэл ханамжийн судалгаагаар номын сангийн үйлчилгээнд 6.89% нь муу, ном сурах бичгийн хүрэлцээ, хангамжид “дунд”, “муу” гэсэн үнэлгээний учир шалтгааныг тодруулж, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчныг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежмент, маркетингийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн удирдлага нь дээд, дунд, доод түвшин гэсэн бүтэц, зохион байгуулалттайгаар тодорхой чиг үүргийн хүрээнд ажилладаг.
- Хөтөлбөрийг ХААИС-ийн бакалаврын сургалтын журам, Хөтөлбөрийн хорооны журамд заасны дагуу хэрэгжүүлдэг.
- Хөтөлбөртэй холбоотой санал хүсэлтийг оюутнуудаас хүлээн авч тухай бүр шийдвэрлэн тайлагнасан байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгчид нь сургуулийн ерөнхий үйл ажиллагаа, стратеги зорилтын хүрээнд ХААИС, МААБС, тэнхим багш гэсэн үе шаттайгаар тайлагнадаг. Хөтөлбөрийг хэрэгжүүлж буй тэнхим хагас жил, бүтэн жилээр тайлагнаж, хэлэлцүүлэн ЭШАлба үзүүлэлт тус бүрээр дүн шинжилгээ хийж МААБС, ХААИС-ийн захирлын зөвлөлөөр хэлэлцүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг 2027 он хүртэл боловсруулсан.
- Сургалтын удирдлагын LMS/MULS системтэй ба 8 веб сувгаар дамжиж олон нийтэд хүрдэг.

Анхаарах асуудал:

- Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж, шинэчлэн боловсруулж дунд богино хугацааны төлөвлөгөөг боловсруулан ажилладаг байх

Зөвлөмж:

- Тайлан хэрэгжилтийг яг тухайн хөтөлбөрийн хүрээнд тусгайлан гаргадаг байх
- Хөтөлбөрийн хэрэгжилт, тайланг цахимжуулах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Тайлант хугацаанд гадаадын 6, ШУТ-ийн 5, дотоодын 2, захиалгат болон гэрээт 8 төсөл хөтөлбөр гэрээт ажлыг хийж гүйцэтгэсэн байна.
- Оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт үндсэн гурван журмын дагуу хамруулдаг байна. Мэргэжлийн хос хөтөлбөртэй.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоог тайлагнадаг ба нийт тэнхимийн хэмжээнд 21 ажлыг зохион байгуулсан байна.
- Төгсөгчдийн холбоотой, олон нийтийн цахим хаягийг үүсгэн төгсөгчидтэй холбогдон ажилладаг.
- Төгсөгчдийг ахисан түвшний буюу магистрийн сургалтанд хамруулж, судалгааг гаргасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт үндсэн гурван журмын дагуу хамруулдаг байна. Мэргэжлийн хос хөтөлбөртэй.

Анхаарах асуудал:

- 21 төсөл, хөтөлбөр гэрээт ажлыг хийж гүйцэтгэсэн боловч үндсэн хөтөлбөрөөс гадуурх ажил дийлэнх хувийг эзэлж байна.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, тогтмолжуулах
- Төгсөгчдийн дунд мэргэжил дээшлүүлэх давтан сургалтыг зохион байгуулах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Элсэгчдийн тоо тайлант хугацаанд буурсан нь нийт орлого буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна.
- Оюутны төлбөр тайлант хугацаанд жилээс жилд өссөн байна.
- Нэг суралцагчдад ноогдох зардал 2021 онд 2.386.882 төгрөг байгаа ба сургалттай холбоотой шууд зардал 91,7%-ийг эзэлж байна.
- Суралцагсдад 2020 онд нийт 9.782.101 төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.
- Мөнгөн бус хөрөнгө оруулалт болон хандивын тайланг гаргасан ба нийт 19.155.440 төгрөг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Нэг суралцагчид ноогдох зардал 2021 онд 2.386.882 төгрөг байгаа ба сургалттай холбоотой шууд зардал 91,7%-ийг эзэлж байгаа нь оюутны сургалтын төлбөрийг оюутнуудад хангалттай сайн зарцуулж байна.

Анхаарах асуудал:

- Оюутны төлбөр тайлант хугацаанд жилээс жилд өсч байгаад анхаарах

Зөвлөмж:

- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг авах талаар судлах, санхүү түүний зарцуулалтын тайлант тогтмол гаргаж байх

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Маркетинг идэвхжүүлэлтийн зорилтыг дэвшүүлсэн.
- Хөтөлбөрийн цахим маркетинг - цахим сурталчилгааг ХААИС, МААБС-ийн цахим хуудсаар дамжуулан явуулдаг.
- Хөтөлбөрөө биет байдлаар сурталчилсан.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Анхаарах асуудал:

- Маркетинг идэвхжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулах
- Сургалт үйлдвэрлэлийн дадлагын чанарыг сайжруулах, үйлдвэрүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх

Зөвлөмж:

- Мэргэжлийн багаас маркетинг идэвхжүүлэлтийн талаар зөвлөгөө авах, хамтарч ажиллах

Шаардлага:

- Маркетинг идэвхжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулж, шат дараатай хэрэгжүүлж ажиллах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар сүүлийн үеийн мэдээллийг сургуулийн веб сайт, нийгмийн сүлжээгээр цахим хэлбэрээр, сонин хэвлэл, сургуулийн, хэвлэмэл хэлбэрээр мэдээлдэг.
- Веб сайтын мэдээллийн иж бүрэн байдал хангалттай, тогтмол ажиллагаа үйл ажиллагаа явуулдаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйлчилгээ

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУС-ын А/79 тоот тушаалаар баталсан журамд нийцүүлэн гаргасан ХААИС-ийн бакалаврын сургалтын журмын дагуу ХААИС-ийн захирлын баталсан элсэлтийн комисс элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.
- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тогтоосон байдал
- Элсэлтийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, 2021 он
- Оюутны гарын авлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрөөр элсүүлэхдээ хими, биологи, математик хичээлээр ерөнхий шалгалтын оноог тооцдог ба босго оноо аль нэг хичээлээр 480-аас доошгүй байна. Элсэгчдийн ерөнхий шалгалтын дундаж оноо сүүлийн 5 жилд 501-559 байгаа нь босго онооноос 21-79-өөр илүү байна.

Анхаарах асуудал:

- Хүсэлт гаргасан оюутныг элсүүлэх боломжийг судлах
- Мэргэжил сурталчлах хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмж:

- Цаашид “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн оюутнуудад зориулсан тусгайлсан чиглүүлэх сургалтыг бий болгон хэрэгжүүлж оюутнууд өөрийн мэргэжлийн онцлог давуу талыг мэдрэх, мэргэжилдээ дур сонирхолтой болоход нь илүү анхааран ажиллах

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн “Оюутны хөгжил” хөтөлбөрийн бодлогын баримт бичиг
- “Оюутны хөгжил” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг “Хаан Кампус хотхон”, “Экологийн цэвэр орчин” зэрэг дэд хөтөлбөрүүд
- Сургалтын бодлого зохицуулалтын албанаас гаргадаг нэгдсэн төлөвлөгөө, график
- ХААИС, МААБС-ийн вэб хуудас болон <http://teacher.muls.edu.mn/>, <http://student.muls.edu.mn/> цахим хуудсаар сургалтын, <https://muls.lib4u.net/> номын сангийн, <https://finance.muls.edu.mn/login.php> санхүүгийн үйлчилгээг авах цахим хаяг
- Зөвлөх багш, сургалтын алба, байрын багш, номын сан, эмчийн зөвлөн туслах үйлчилгээний чанарын үнэлгээ, ахиц 2017, 2019 он
- Суралцагчдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын жагсаалт, гаргасан амжилтууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ийн “Оюутны хөгжил 2018-2028” хөтөлбөрийн хүрээнд оюутан суралцагчдыг хөгжүүлэх, төлөвшүүлэх ажлыг бүрэлдэхүүн сургуулийн захиргаа, сургалтын алба болон харьяа тэнхмийн төлөвлөгөөнд тусган, сургалтын алба, тэнхим оюутны зөвлөл, клубүүд гардан хэрэгжүүлж, 6 чиглэлээр 24 төрлийн үйлчилгээг оюутанд үзүүлж байна.
- Зөвлөн туслах үйлчилгээний талаархи оюутны сэтгэл ханамжийн судалгааны 2019 оны дүнг өмнөх судалгаатай харьцуулахад тэнхимийн туслах 1.1; сургалтын менежер 1.4; эрүүл мэндийн үйлчилгээний чанар 2; номын сангийн үйлчилгээ 1.6–аар нэмэгдсэн байна.
- Суралцагчдын тоо харьцангуй цөөн байгаагаас шалтгаалан зөвлөх багш оюутан нэг бүрт хүрч ажиллах, сургалтын талаар зөвлөн туслах үйлчилгээг тогтмол үзүүлэх боломж бүрдсэн.
- Оюутнуудаас хичээл заасан багшийн талаар сэтгэл ханамжийн судалгааг цахимаар улирал бүрийн төгсгөлд авч хэвшсэн.
- Профессор багш нарын хэрэгжүүлж буй эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажилд оюутнуудыг оролцуулснаар судалгааны ажил гүйцэтгэх арга барилд суралцахын зэрэгцээ төгсөлтийн ажлаа судалгаагаар хамгаалах боломж нэмэгдэж, сүүлийн 2 жилд эрдэм шинжилгээний илтгэл хэлэлцүүлсэн оюутны тоо 2 дахин өссөн байна.

Анхаарах асуудал:

- Оюутанд үзүүлэх зөвлөн туслах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулах, үр өгөөжийг тооцдог байх

Зөвлөмж:

- Оюутанд үзүүлж буй үйлчилгээний чанар төдийгүй, тухайн орчны тав тух, нөхцлийг бүрдүүлэхэд илүү анхаарах

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- “Микробиологи”, “Албан хэрэг хөтлөлт” дугуйлангийн хөтөлбөр
- Суралцагчдын дунд зохион байгуулсан соёл хүмүүжлийн болон мэргэжлийн уралдаан тэмцээний тайлан
- Оюутны сайн дурын ажил гүйцэтгэсэн байдал, үр дүн

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Их сургуулийн хэмжээнд оюутнуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх, оюутныг хөгжүүлэх зорилгоор техник, урлаг, спорт, цэнгээнт бүжгийн 30 гаруй клуб, дугуйлан хичээллэдэг. МААБС-ийн багш нар хөтөлбөрөөр суралцагч оюутнуудын дунд “Албан хэрэг хөтлөлт”, “Микробиологи” зэрэг дугуйлан хичээллүүлж, бичиг баримт боловсруулах, судалгааны арга зүйд сургах чиглэлээр хөгжүүлдэг.
- 2016-2020 онд “Орлоготой оюутан” хөтөлбөр хэрэгжүүлж, оюутнуудыг хөдөлмөр эрхлэх, дадлагажих, төгсөөд ажлын байртай болоход нь туслах зорилгоор “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг байгуулж, 3,4-р ангийн оюутнуудыг цагийн ажилд зуучлах, хөдөлмөрийн зах зээлийн харилцаанд бэлтгэх байдлаар ажиллаж байсан.
- Оюутнууд жил бүр чацаргана хураах сайн дурын ажилд оролцож, орлогоороо сайн үйлсийн аян, мэргэжил сурталчлах өдөрлөг зохиохоос гадна сургуулиас зохион

байгуулсан спортын тэмцээн, урлагын наадам, танилцах аялал, өдөрлөг зэрэгт идэвхтэй оролцдог.

- ХААИС-ийн захирлын тушаалаар сурлагын өндөр амжилт гаргасан оюутанд батламж олгож, төлбөрийн хөнгөлөлт үзүүлдэг ба тус хөтөлбөрийн 283 оюутан батламж авч, 26 оюутан 20%-ийн, 3 оюутан 50%-ийн хөнгөлөлт эдэлж, гадны тэтгэлэгт 10 гаруй оюутан хамрагдсан байна.

Анхаарах асуудал:

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх, оюутан бүрт хүрч ажиллаж нөхцлийг бүрдүүлэх
- Оюутны сайн дурын ажлыг дэмжих, үнэлгээг тодорхой болгох
- Тэтгэлэгт хамрагдах оюутны тоог нэмэгдүүлэх

Шаардлага:

- Мэргэжлийн чиглэлээр клуб, дугуйланд хамрагдах хүсэлтэй оюутнуудын судалгаа гаргаж, хүсэл сонирхолд нь нийцсэн агуулгатай хөтөлбөрөөр тогтмол хичээллүүлж, үр дүнг тайлагнах, улмаар мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцох замыг нээж өгөх
- Хөтөлбөрийн оюутнуудын хичээлээс гадуурхи нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ХААИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа, (2016-2021он)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МААБС-ийн захирлын тушаалыг үндэслэн, кредитийн дүйцүүлэлтийг сургалтын хөтөлбөрийн эрхлэгч хийж, шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэдэг. Журамд шилжин суралцагчдын дүйцүүлсэн кредит 12-оос ихгүй, голч 2,0-с доошгүй байхаар заасан.
- Шилжилт хөдөлгөөний судалгаанаас харахад тайлангийн хугацаанд 94 оюутан сургуулиас гарсаны 64% нь жилийн чөлөө авч, 12% нь сурлагаар хасагдсан. Харин шилжин ирсэн 86 оюутны 36% нь бусад сургуулиас, 61% нь жилийн чөлөөнөөс нь ирж, чөлөө авсан оюутнуудын 90 орчим хувь нь эргэн ирж суралцдаг гэж дүгнэжээ.

Анхаарах асуудал:

- Сургууль орхисон оюутны шалтгааныг нарийвчлан судалж, цаашид энэ чиглэлээр авах арга хэмжээг төлөвлөдөг байх

Зөвлөмж:

- Зөвлөх багш жилийн чөлөө авах хүсэлтэй оюутнуудад зөвлөдөг, үргэлжлүүлэн суралцах боломжийг бүрдүүлэхэд тусладаг байх

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- БСШУ сайдын “Дээд боловсролын диплом олгох журам”

- ХЧАБ хөтөлбөрөөр төгсөгчдийн дипломын хуулбар

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийг бүрэн судалж, үнэлгээний голч дүн 2-оос доошгүй бол төгсөгчөөр бүртгэдэг. Оюутны голч дүн 2.5 ба түүнээс дээш бол шалгалт, дипломын аль нэгийг өөрөө сонгож, 2.5-аас бага бол төгсөлтийн шалгалт өгч төгсдөг.
- “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн бакалаврын зэргийн диплом нь сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн кредит цаг, үнэлгээ бүхий МУ-ын Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өгсөн дугаар, ХААИС-ийн бүртгэлийн дугаартай байх ба ХААИС-ийн удирдах зөвлөлийн дарга, захирал, төгсөлтийн комиссын дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирлын гарын үсэг, тамгаар баталгаажсан байна.

Зөвлөмж:

- Оюутны төгсөлтийн ажлын сэдвийг оновчтой тогтоох, хөтөлбөрийн онцлог, давуу талыг харуулсан судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх (*хөтөлбөрийн ялгарах чанар болох хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын үнэлгээний чиглэлээр гэх мэт*)

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- “ХААИС-ийн профессор багш ажиллуулах журам”
- “ХААИС-ийн багшийн хөгжил” хөтөлбөр
- “Шавь сургалт-Оюуны капитал” хөтөлбөр
- Багшийн гарын авлага
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн цагийн ачаалал, гүйцэтгэл
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжил хөтөлбөр”-ийн хүрээнд хүний нөөцийн тогтвортой ажиллах, мэргэшсэн байдлыг хангах үүднээс “Шавь сургалт-оюуны капитал” хөтөлбөрийг хэрэгжүүлж, тайлангийн хугацаанд өөрийн төгсөгчдөөс 3 багш, судлаачийг бэлтгэсэн.
- Багшлах бүрэлдэхүүний хувьд 9-26 жилийн ажлын туршлагатай, 78.5% нь докторын зэрэгтэй мэргэжлийн чадамжтай баг ажилладаг.

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхмийн багш суралцагчийн тоон харьцаа сүүлийн 5 жилд 9.4-12.8 байгаа нь зохистой хэмжээнд байна.
- Багшийг чадамжийн түвшингээр нь албан тушаалын 5 зэрэглэлд ажиллуулдаг. Чадамжийг сургалт, заах арга зүй; эрдэм шинжилгээ, инноваци; мэргэжлийн үйл ажиллагаа; багшийн ур чадвар, ахиц дэвшил гэсэн 4 шалгуур үзүүлэлтээр үнэлж, албан тушаалын зэрэглэлийг тогтоох ба 80-аас дээш үнэлгээ авсан тохиолдолд багшийг шатлал ахиулдаг. Тайлангийн хугацаанд 3 багш ахлах багшийн, 2 багш дэд профессорын зэрэглэлд дэвшин, 5 дэд профессор, 8 ахлах багш, 1 багшийн бүрэлдэхүүнтэй баг ажиллаж байна

Анхаарах асуудал:

- Бүрэлдэхүүн сургуулийн хэмжээнд хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангах, чадваржуулах, ажлын байрны давтан сургалт явуулах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэх

Зөвлөмж:

- “Шавь сургалт-Оюуны капитал” гэх мэт багшийг хөгжүүлэх, дэмжин туслах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэгийг тодорхой болгох

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны төлөвлөгөө
- Багшийн заах арга зүйн талаар хийсэн үнэлгээ
- Багшийн хөгжлийн төлөвлөгөө, багшийн ажлын дэвтэр
- Мэргэжил дээшлүүлэлтийн судалгаа, тайлан

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн тогтвортой хөгжлийг хангах, бие даан хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, хувь хүнийг чадавхжуулах зорилго бүхий багшийн хөгжлийн төвтэй. “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор багш нараас судалгаа авч сургалтанд хамруулдаг. Сүүлийн 5 жилд сурган заах арга, гадаад хэл, мэдээллийн технологи, судалгааны арга зүйн чиглэлээр жил бүр 13-23 багш сургалтанд хамрагдсан байна.
- “Багшийн хөгжил” хөтөлбөрийн хүрээнд 5 чадамж бүхий багш бэлтгэх арга хэлбэрийг боловсруулан, дотоод гадаадын их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтрах, санхүүжилтээр дэмжих байдлаар хэрэгжилтийг хангаж ажилладаг.
- Тайлангийн хугацаанд БНСУ, БНХАУ, ОХУ, БНТУ зэрэг орнуудад багш нар мэргэжил дээшлүүлж, 3 багш докторын зэрэг хамгаалсан.
- Багш, судлаачдын судалгааны ажил гүйцэтгэх орчин нөхцлийг сайжруулж, орчин үеийн тоног хэрэгсэл бүхий 8 лабораторийг ашиглалтанд оруулсан.
- Сургалт үйлдвэрлэлийн уялдааг хангах төлөвлөлтийн хүрээнд залуу багш нарыг үйлдвэрлэл дээр дадлагажуулсан байна (САМО институт, Мэргэжлийн хяналтын лаборатори, Сүү ХК, Хүнс комплекс, АПУ ХК, Хатан сүйх гэх мэт)
- Сүүлийн 5 жилд тус хөтөлбөрийн мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлийн багш нар давхардсан тоогоор дотоодод 46, гадаадад 12 багш мэргэжил дээшлүүлсэн байна.

Анхаарах асуудал:

- Гадаад дотоодод сургалт семинарт хамрагдсан багш нарын ажлын үр дүн, ахиц дэвшлийг үнэлэх, санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгох

- “Багшийн хөгжлийн төв”-ийн зохион байгуулсан сургалт, семинар үйл ажиллагааны үр дүнг тооцон, сургалтын өгөөжийг үнэлэх

Шаардлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч мэргэжлийн багш нарыг нийгмийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан нарийн мэргэшүүлэх талаар судалгаатай ажиллаж, чадавхжуулах, эрдмийн зэрэг, цолыг ахиулахад чиглэсэн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Гүйцэтгэсэн шинжлэх ухааны болон инновацийн төслийн үр дүн, хэрэгжүүлсэн хөтөлбөр, оюуны өмчийн бүтээлийн гэрчилгээ
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн үр дүн
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал
- Багш нарын бичиж хэвлүүлсэн ном, сурах бичиг, гарын авлага

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МААБС-ийн судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн багш нар дараах судалгааны ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнд:
 - *Үлдээгдэл бодисын хяналт, үнэлгээ*
 - *ХАА-н үйлдвэрлэлийн зохистой дадал*
 - *Хүнс, ХАА-н үйлдвэрлэлийн эрүүл ахуй*
 - *ХАА-н гаралтай бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ*
 - *Эмгэг төрүүлэгч бичил биетнийг оношлох, сэргийлэх арга*
 - *Бүтээгдэхүүний аюулгүй байдлыг микробиологийн үнэлгээ*
 - *ХАА, хүнсний аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын асуудлууд зэрэг болно.*
- Багш нар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, тайлангийн хугацаанд 29 оюуны өмчийн эрх, стандарт, заавар, 37 ШУТ, инновацийн төсөл, 29 гэрээт ажил, 27 олон улсын төсөл, 17 дотоодын төсөл хэрэгжүүлсэн байна.
- ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх төслийн хүрээнд ХАА-н зохистой дадал нэвтрүүлэх стандартыг боловсруулж, ХАА-н бүтээгдэхүүний хяналт үнэлгээний төв лабораторийг МААБС дээр байгуулан судалгаа, шинжилгээний ажлыг явуулж байна.
- Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар “Ногоон алт, Экологийн цэвэр бүтээгдэхүүн бэлтгэх” (2019-2020), “Органик мал аж ахуйд хэрэглэх байгалийн гаралтай шинэ эм, бэлдмэлийн технологи” зэрэг төслийг Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж, мах, сүүний аюулгүй байдлын судалгаа хийж, малын дэлэнгийн үрэвсэлтэй үнээнд антибиотикийг орлуулах шинэ органик бэлдмэл ашиглах технологийг нэвтрүүлээд байна.
- Жил бүр багш оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, судалгааны ажлын үр дүнг шүүн хэлэлцдэг ба жилд 100 гаруй өгүүллийг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн бичиг, ХААШУТС-д нийтэлж, олны хүртээл болгосон ба улсын хэмжээнд 103, олон улсын түвшинд 101 илтгэл, өгүүлэл бичиж хэлэлцүүлсэн байна. Импакт фактортай сэтгүүлд 20 гаруй өгүүлэл, нийтдээ 214 удаа эшлэгдсэн байна

Анхаарах асуудал:

- Судалгааны лабораторийн чадавхийг бэхжүүлэх, итгэмжлүүлэх

- Багш нарын ном, сурах бичиг, гарын авлага бичиж хэвлүүлэх ажлыг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх

Зөвлөмж:

- Багш нар гадаадын сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх болон эшлэгдсэн тохиолдолд урамшуулдаг тогтолцоотой болох

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багш болон тэнхимийн өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /аттестатчлал, оюутны үнэлгээ/
- Багшийн сургалтын үйл ажиллагааны баримт, материал
- ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам
- “Цахим хичээлд хөндлөнгийн үнэлгээ хийх тухай” А/37 тушаал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн жилийн төгсгөлд багш бүр өөрийн үнэлгээний тайланг А,Б,В шалгуурын дагуу бичиж, сургуулийн хэмжээнд хэлэлцүүлдэг ба 300 хүртэл оноо өгч үнэлдэг. Багш нарын өөрийн үнэлгээний тайлангийн дундаж үнэлгээ 90% байна.
- Хөндлөнгийн үнэлгээг багшийн хөгжил, чадамжийн түвшингээр үнэлэх ба багшийн зэрэглэлээс хамааран 2-5 жил тутамд хийж, зэрэглэл ахиулдаг.
- Их сургуулийн хэмжээнд 2020-2021оны хичээлийн жилд зохион байгуулсан цахим хичээлийн сургалтын технологид хөндлөнгийн үнэлгээ хийхэд тус сургуулийн 2 багш шалгарч мөнгөн урамшуулал хүртсэн байна.
- Мөн оюутны санал асуулгаар багшийн сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг үнэлэхэд 67,4% сэтгэл ханамжтай, заах арга зүйг 74,7% нь сэтгэл ханамжтай гэж үнэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Оюутны санал асуулгаар багш нарын сурган, заах арга зүйн үнэлгээний 2,3-5,6% нь сэтгэл ханамжгүй гэж үнэлэгдсэнийг анхаарч шалтгааныг судлах

Зөвлөмж:

- Профессор багш нарын ажлын гүйцэтгэл, үр дүнгээс хамаарсан урамшууллын тогтолцоог эрэлхийлж, хэрэгжүүлэх

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем, мэргэжлийн хөтөлбөрийн хороотой.
- Чанарын баталгаажуулалтын шинэ журмыг 2019 онд боловсруулан, хэрэгжилтэнд үнэлэлт дүгнэлт хяналт тавьдаг.
- Оролцогч талуудын жигд оролцоог хангахад 2 чиглэлийн арга хэлбэрийг ашиглаж байна. Мониторинг-зөвлөмж, ULMS систем
- 2017 онд хөтөлбөрийг шинэчлэн сайжруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн хөтөлбөрийн хорооны ажлын үр дүн тодорхойгүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмыг зохион байгуулж, сайжруулах
- Мэргэжлийн хөтөлбөрийн хороог шинэчлэх, чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг 2006-2021 оноор гаргасан ба мэргэжлээрээ ажил эрхлэлт 54,5 %, нийт ажил эрхлэлт 90% байна.
- Сэтгэл ханамжийн судалгааг оюутан, ажил олгогч, төгсөгч гэсэн үзүүлэлтээр гаргасан байна.
- 19 байгууллагын төлөөлөл бүхий ажил олгогчдын судалгаа
- Судалгаанд оролцсон төгсөгчдийн 60 хувь 7 хоногоос жилийн дотор ажилд орсон байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрт суралцах явцад хос хөтөлбөрөөр сурч төгсөх боломжтой байна.
- Оюутан, төгсөгчидтэй хийсэн уулзалтаар энэхүү хөтөлбөрийг төгсөгч нар нь бусад энэ чиглэлийн хөтөлбөр хэрэгжүүлэгч сургуулиудын төгсөгч нараас ажлын байранд зөвхөн ганц хүнсний аюулгүй байдал гэхгүйгээр арьс шир, ноос ноолуур гэх мэт ХАА бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг давхар хянах, хөрвөн ажиллах боломжтой.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Шаардлагатай бол олгож буй эрдмийн зэрэг болон мэргэжлийн нэр хүндийг дэмжих зорилгоор үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөр нэг удаа магадлан итгэмжлэлд хамрагдсан ба 2 дахь удаа хамрагдахаар ажиллаж байна.
- Магадлан итгэмжлэх ажлын хүрээнд сэтгэл ханамжийн судалгааг үндэслэн хөтөлбөрт шинэчлэл хийсэн.

- Хүнс, ХАА-н чиглэлийн мэргэжлийн холбоодтой хамтран ажилладаг.
- Хөтөлбөрийг гадаадын ижил төстэй хөтөлбөртэй жишин харьцуулах замаар шинэчлэн боловсруулсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ОХУ-ын Новосибирск, Буриад, Эрхүүгийн ХААИС, Солонгосын Чонбукийн ҮИС, БНХАУ-ын Хэнаны ХААИС-д "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ" мэргэжлээр хос хөтөлбөрөөр суралцах боломжийг бүрдүүлсэн.

Анхаарах асуудал:

- Үндэсний болон олон улсын байгууллагаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зорилт тавин, төлөвлөгөө боловсруулж ажиллах

Зөвлөмж:

- ОХУ-ын Новосибирск, Буриад, Эрхүүгийн ХААИС, Солонгосын Чонбукийн ҮИС, БНХАУ-ын Хэнаны ХААИС-д "Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ" мэргэжлээр хос хөтөлбөрөөр суралцах боломжийг бүрдүүлсэн хэдий ч суралцагчийн тоо хангалтгүй, оролцогч талуудын идэвхи сул байгаад дүгнэлт хийх

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	2	1		Хөтөлбөрийн агуулгад хүнсний технологийн суурь мэдлэг олгох цаг хангалттай биш
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1		Сургалт үйлдвэрлэлийн дадлагын чанарыг сайжруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх идэвхжүүлэх ажил дутмаг
5	Суралцагчид чиглэсэн үйлчилгээ	4	1		Хөтөлбөрийн оюутнуудын сайн дурын ажлыг дэмжих, урамшуулах тогтолцоо төлөвшөөгүй
6	Багшлах бүрэлдэхүүн	3	1		Багш тасралтгүй хөгжих, нарийн мэргэших боломжийг бүрэн хангаагүй
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	3			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал аж ахуй биотехнологийн сургуулийн “Хүнсний чанар, аюулгүй байдал” бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	ХААИС, Мал аж ахуй, биотехнологийн сургууль
Хөтөлбөрийн нэр	Хүнсний чанар, аюулгүй байдал
Хөтөлбөрийн индекс	Бакалаврын хөтөлбөр 072103
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөрийн онцлогийг нийгэмд (элсэгч, ажил олгогч, хамтран ажилладаг байгууллага) таниулах ажлыг илүү оновчтой зохион байгуулах ➤ “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийг хэрэгжүүлдэг дотоодын их сургуулийн хөтөлбөртэй задлан шинжлэх байдлаар харьцуулж, нийгмийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> ➤ “Хүнсний чанар, аюулгүй байдал” нь маш өргөн хүрээг хамрах ойлголт бөгөөд хөдөө аж ахуйгаас гаралтай төдийгүй бусад бүх хүнстэй холбоотой асуудлыг ч хамрах боломжтойг судлах ➤ Ижил индекс бүхий мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэдэг үндэсний бусад сургуулийн сургалтын хөтөлбөрийн сайн туршлагын дагуу өөрчлөлт, сайжруулалт хийх
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	<ul style="list-style-type: none"> ➤ Суралцагч төвтэй сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвхөн хичээл сургалтын ажил төдийгүй үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөртэй холбоотой бүхий л үйл ажиллагааны сайжруулалтыг үр дүнд төвлөрсөн хэлбэрээр тогтмол хийж, хэвших ➤ Сургалт-үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх замаар хөтөлбөрийг таниулан сурталчлах
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> ➤ “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн оюутнуудад зориулсан тусгайлсан чиглүүлэх сургалтыг бий болгон хэрэгжүүлж оюутнууд өөрийн мэргэжлийн онцлог давуу талыг мэдрэх, мэргэжилдээ дур сонирхолтой болоход нь илүү дэмжин ажиллах
Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн	<ul style="list-style-type: none"> ➤ Багш нар төсөл, хөтөлбөр бичих, хэрэгжүүлэх, гадаадын сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх болон эшлэгдсэн тохиолдолд урамшуулдаг тогтолцоотой болох
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	<ul style="list-style-type: none"> ➤ ОХУ-ын Новосибирск, Буриад, Эрхүүгийн ХААИС, Солонгосын Чонбукийн УИС, БНХАУ-ын Хэнаны ХААИС-д “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн үнэлгээ” мэргэжлээр хос хөтөлбөрөөр суралцагчийн тоог нэмэгдүүлэх ➤ Чанарын баталгаажуулалтын дотоодын болон хөндлөнгийн хяналтыг эрчимжүүлэх
ШААРДЛАГА	
Шалгуур 2.1	<ul style="list-style-type: none"> ➤ “Хүнсний чанар, аюулгүй байдал” хөтөлбөрийн агуулгад хүнсний үйлдвэрлэлийн технологийн суурь мэдлэг олгох цагийг нэмэгдүүлэх
Шалгуур 4.4	<ul style="list-style-type: none"> ➤ Маркетинг идэвхжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулж, шат дараатай хэрэгжүүлж ажиллах
Шалгуур 5.3	<ul style="list-style-type: none"> ➤ Мэргэжлийн чиглэлээр клуб, дугуйланд хамрагдах хүсэлтэй оюутнуудын судалгаа гаргаж, хүсэл сонирхолд нь нийцсэн агуулгатай хөтөлбөрөөр тогтмол хичээллүүлж, үр дүнг тайлагнах, улмаар мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцох замыг нээж өгөх ➤ Хөтөлбөрийн оюутнуудын хичээлээс гадуурхи нийгэмд чиглэсэн үйл ажиллагааг дэмжих, оролцоог нэмэгдүүлэх
Шалгуур 6.2	<ul style="list-style-type: none"> ➤ Хөтөлбөр хэрэгжүүлэгч мэргэжлийн багш нарыг нийгмийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан нарийн мэргэшүүлэх талаар судалгаатай ажиллаж, чадавхжуулах, эрдмийн зэрэг, цолыг ахиулахад чиглэсэн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Я.Баярхүү/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Г. Оюун/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../А. Амаржаргал/

IV.Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Утас	Ажилласан жил	Заадаг хичээл
1	Б. Энхжаргал	Дэд. проф.	99299327	21	Хүнс судлал Ургамлын өвчин Бүтээгдэхүүний үлдэгдэл бодисын хяналт
2	Д. Дамдинсүрэн	Ахлах багш	99050658	14	Чанарын хяналт, стандартчилал ХААн бүтээгдэхүүний олон улсын хяналт Байцаагчийн эрх зүй
3	Б. Сарантуяа	Ахлах багш	91911622	30	ХААн бүтээгдэхүүний микробиологи ХААн бүтээгдэхүүний эрсдлийн үнэлгээ
4	Д. Найдандорж	Ахлах багш	86097998	12	Ургамылын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэлгээ Хүнс үйлдвэрлэлийн тогтвортой хөгжил
5	Э. Төмөртогтох	Дэд. проф	99060249	24	Мах махан бүтээгдэхүүний үнэлгээ Сүү сүүн бүтээгдэхүүний үнэлгээ
6	З. Цэрэнханд	Ахлах багш	94045621	11	Мах махан бүтээгдэхүүний үнэлгээ Сүү сүүн бүтээгдэхүүний үнэлгээ Сургалтын дадлага
7	Б. Баасанжаргал	Ахлах багш	80706611	26	Бүтээгдэхүүний сав баглаа боодлын эрүүл ахуй үнэлгээ
8	Б. Итгэл	Дэд. проф	99094933	23	Ноос ноолуур, арьс ширэн бүтээгдэхүүний үнэлгээ

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Утас
1	Т. Оюундарь	I	86688695
2	М. Солонго	I	89404945
3	Д. Эрдэнэсолонго	I	85648415
4	С. Уранчимэг	I	95831154
5	Б. Ганчимэг	I	90355805
6	Б. Үүрийнтуяа	II	94518810
7	М. Түмэнжаргал	II	80148436
8	О. Пүрэв-Очир	II	88404784
9	Б. Хулан	II	99586852
10	С. Энэрэл	II	85887887
11	М. Отгонзул	III	85272755
12	Ж. Цагаандарь	III	88938506
13	Э. Нямдаваа	III	89830903
14	Б. Зоригтсайхан	III	88222632

15	Э. Дэлгэрсайхан	III	88301499
16	Л. Түмэн-Өлзий	III	80681208
17	Г. Төртогтох	IV	88819508
18	Б. Отгонцэцэг	IV	95203880
19	Х. Өнөржаргал	IV	99818309
20	Н. Орхонтуул	IV	95127921
21	Ц. Адьяасүрэн	IV	88732712

III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Утас
1	О. Нямхишиг	Витсамо үйлдвэрийн дарга	99108658
2	Эрхэмбаяр	Хөвсгөл аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газрын дарга	86092388
3	Ж. Ариунзул	“Траст трейд” ХХК хүний нөөцийн албаны дарга	94047502
4	Д. Пүрэвжаргал	Ханлаб ХХК, чанарын хяналтын менежер	94001047
5	Ч. Номин-Эрдэнэ	“Түмэн шувуут” ХК шувууны аж ахуй 1 захирал	88001745
6	Хонгорзул	СУ сүлжээ дэлгүүрийн ээлжийн ахлагч	99248496

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Утас
1	Г. Баасандолгор	2015	Булган аймгийн засаг даргын тамгын газар, Хүнс ХАА-н асуудал хариуцсан мэргэжилтэн	86581313
2	Ц. Хулан	2015	Сэлэнгэ аймгийн Гаалийн хорио цээрийн алба, Хүнсний чанар, стандартын хяналтын гаалийн улсын байцаагч	99716081
3	Э. Пүрэвдулам	2016	Магистрант	90700311
4	Ц. Нямжаргал	2016	Жем интернэшнл, эрүүл ахуйч	99516601
5	Х. Цэвэлмаа	2016	Магистрант	96522569
6	О. Номиндарь	2017	МАНЭШХ эрдэм шинжилгээний ажилтан	92088844
7	М. Баянмөнх	2017	Траст трейд лабораторийн эрхлэгч	95047502
8	Б. Мөнгөнтуяа	2017	“Их тойруухудалдааны төв” эрүүл ахуйч	89118344
9	Ш. Тэмүүлэн	2018	Ханлаб, микробиологич	88158336
10	Г. Хашбаатар	2018	АПУ, нярав	91040677
11	А. Эрдэнэчимэг	2018	Геомин ХХК, эрүүл ахуйч	80135031
12	Б. Батцэцэг	2018	Арвайн үндэс ХХК, чанарын мэргэжилтэн	88709285
13	Я. Отгонжаргал	2019	Өмнөговь, Ус цэвэрлэх байгууламж	88768853
14	Б. Болортуяа	2019	Түмэн шувуут	80161227
15	Б. Мөнхбаяр	2020	Дорноговь аймгийн Гаалийн хорио цээрийн алба, Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч	96960108

16	Б. Энхтуяа	2020	Өмнөговь аймгийн Гаалийн хорио цээрийн алба, Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч	89013938
17	О. Энхчимэд	2020	Грийн груп	86252333
18	Ү. Батдэлгэр	2020	Сэлэнгэ аймгийн Гаалийн хорио цээрийн алба, Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч	99595569
19	Г. Мөнхсаруул	2021	АПУ, технологич	99226234
20	Н. Мөнхжин	2021	Нарантуул ОУХТ эрүүл ахуйч	99588894
21	Б. Уянга	2021	СУ хоолны үйлдвэрт чанар шалгагч	89024072

V.Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал


ХӨДӨӨ АЖ АХУЙНИХ СУРГУУЛЬ
**МАЛ АЖ АХУЙ БИОТЕХНОЛОГИЙН
СУРГУУЛЬ**
17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо,
Зайсан-5, Утас: 7510 7777 222, 223
И-мэйл: asbt@muls.edu.mn
Вэб сайт: www.muls.edu.mn

2022.04.27 № 01/127
танай _____-ны № _____-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлийн шинжээчийн багийн ХААИС, Мал Аж Ахуй, Биотехнологийн Сургуулийн "Хүнсний чанар, аюулгүй байдал" бакалаврын (D072103) хөтөлбөрт өгсөн хөндлөнгийн үнэлгээний тайланг 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хүлээн авч танилцав.

Тайланд тусгагдсан зөвлөмж, шаардлагыг хүлээн авч цаашид үйл ажиллагаандаа тусган, хэрэгжүүлж ажиллах болно.

Бидэнтэй хамтран ажилласан та бүхэнд баярлалаа.

ЗАХИРАЛ  О.БААТАРЦОГТ

2022 605 067

D: Documents of SASB/2016/Sent A5

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан(огноо)
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж/Recommendations/

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан(огноо)
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж/Recommendations/